

МОНГОЛ ДАХЬ БУРХАНЫ ШАШНЫ УЛАМЖЛАЛ (XIV зууны эцэс -XVI зуун)

Д.Энхцэцэг

Товч утга: Юань улсаас хойш “хаадын төр-шашны бодлого үгүй болж”, “бөө мөргөл сэргэсэн гэж үздэг. Тэгвэл сурвалж бичгүүдэд XV-XVI зууны эхэн үеийн бурханы шашны түүхэнд холбогдох цөөн баримт үлджээ. Эдгээр нь Усгал хаан болон Энхзоригт хаан, Эсэн тайш, Мандуул хаан, Болох жонон, Батмөнх Даян хаан, Түмэн засагт хааны үед холбогдох ажээ. Энэ нь улсаас хойш ч Бурханы шашны олон урсгалууд, бөө мөргөлийн уламжлалт ёс, зан үйлтэй нэгдэн сүлэлдэж, уусан шингээж, шинэ дүр төрхтэй болон өнө удаан оршин тогтносон түүхэн уламжлалыг харуулж байна.

Түлхүүр үг: “Тойн Ирэнчинсамбууд (1390-ээд он) уламжилсан зарилаг”, хаадын лам, Эсэн, Сэндаиширийг улсын багш өргөмжлөв, Батмөнх Даян хааны багш (лам)болон бөө хоёр, Мандуул хаан, Болох жонон нар Гармын ёсны ламыг залсан, Түмэн засагт хаан ба илдэн зангидагч Гарма лам.

Шашин бол нийгмийн ухамсарын хэлбэр, ертөнцийг тусгасан хүний ухамсар оюун санааны бүтээгдхүүн, ер бишийн хүчин, далдын бишрэхүйд тулгуурлан хүнд итгэл бишрэлийг олгох үзэл санааны нарийн нэгдмэл систем юм. “Шашин бол сүсэглэхүй, шүтэхүй, гэгээрэхүй. Өөрийн үзэл номлолоор нөхцөлдөн буй болсон ертөнцийг үзэхүйн системтэй, сүсэглэхүйн цогц бүрдлүүдийг өөртөө багтаасан, шашны онол сургаалаар хүнийг гэгээрэхүйн мөрд хөтлөгч, шүтэхүйн арга билгийг өөртөө багтаасан, нийгэмд тодорхой үүрэг бүхий дэд тогтолцооны шинж төлвийг хадгалагч онцгой үзэгдэл” гэж үздэг. Шашин хүний амьдралд эерэг, сөрөг талаар нөлөөлж ирсэн нь тодорхой. Энэхүү зөрчилт чанар өөрийгөө шинэчлэх замаар өсөн дэвшиж, нийгмийн оюуны дэвшилттэй шүтэлцээтэйгээр улиран гүнзгийрсээр ирсэн.

“Хүн төрөлхтөний оюун санааны хөгжлийн явцад өөрөө өөрийгөө дээдлэн шүтээн болгох үйл явц байгалынхаа жам ёсоор бурханы шашин”¹ буй болгосныг монголчууд түүхэн хөгжийн олон үе дамжин уламжлан ирсэн түүхтэй. Буддын шашин монгол газар анх нэвтрэхдээ дэлхий бусад ард түмний нэгэн адил улс төрийн зорилгоор ирж, шашин-төрийн хэргийг хослон тусгах “хос ёсны зарчим” эртний улсуудын үеэс эхлэлтэй. Монгол улсын их эзэн Чингис хаан “ертөнцийн аливаа үйл, улс гэрийг засан тохинуулах, ард иргэдийг захиран жолоодох нэн тэргүүнээ өөрийн эрхэнд орж буй олон овог аймгийг өнө удаан хэрхэн захирч байх талаар санаа тавьж “Биеийг хураахаас сэтгэлийг нь хураахтун. Сэтгэлийг

¹ Гегель. Философия религий в 2-х томах. М., 1976, Т.I, с.517

нь хурааваас бие нь хамтдаа ирэх” ёсыг баримтлан эрдэмтэн, мэргэдийг урьж санал солилцож байжээ. “Хаан миний бие сууринаа сууснаас янагш төр улсыг илбэн засахад”² “түмэн олны сэтгэлийг эзэмдэх оюуны хүч, номын ухаан” буюу “төрийн хүнд номын хүн нэн эрхэм” хэмээх утгаар хос ёсыг хэрэгжүүлэхийг эрхэмлэж, лам хуврага³ эрдэмтэн, мэргэдийг урьж санал солилцож байжээ. Хожим түүнийг залгамжлагч монгол хаад өөр өөрийн цаг үед энэхүү хоёр ёсны зарчмыг улс орны амьдралд хэрэгжүүлэн, бурхны шашныг төрийн шашин болгон шүтжээ. Буддизмыг сохроор шүтэж, хуулбарлан авч байсангүй өөрсдөө бүтээх, туурвих орчуулах, номлох ажлыг төрөлх хэлээрээ явуулж иржээ. XIII-XIV зууны үед Монгол лам нар Энэтхэг, Түвэд хэлнээс Бурхны шашны ном тэргүүтнийг орчуулж, төрөлх хэлээр хурал номоо урин уншихад тохируулан уншлагын судар зэргийг орчуулж, тайлбар сэлт хийн, залбирал, магтаал, ерөөл номыг монголоор уншихад зориулж монгол дэг, жаягийг бий болгоход их үүрэг гүйцэтгэсэн нь эдүгээ хүртэл уламжилжээ. Ийнхүү “хурал ном хурж ... уншлага заллага хийгээд гүн ухааны судар шастирыг зохион бурхны шашныг үндэсний шашны хэмжээнд хүргэж чадсан” бөгөөд Буддизмд хийсэн томоохон шинэчлэлт болж “монголын өвөрмөц онцлог бүхий үндэсний шашныг буй болгож” чадсан билээ. Монгол лам нар эх хэлээрээ туурвисан, орчуулсан залбирал, сан, тахилга, яруу найраг, ерөөл магтаал тэргүүтэн их хөлгөн судрууд нь шашин суртахуун хүний оюун санаанд гүн шингэж, ертөнцийг үзэх үзлийг төлөвшүүлэн үеэс үед уламжлан, урт удаан хугацаанд ахуй амьдрал, зан суртахуунд хадгалагдан оршсоор байсан.

Юань улсаас хойш эртний их хаадын үеэс уламжилсан бурханы шашин халагдан мартагдсангүй монголчуудын ахуй амьдрал зан үйлд уусан шингэж “монгол агуулгатай болж” хаадын гэр өргөөгөөр, Алтан урагт хаадын ахмад болон, отгон хөвгүүдийн голомтоор дамжин уламжилсаар нийгэм-улс төр, оюун санааны амьдралд үүргээ гүйцэтгэсээр байсан.

Эзэнт гүрэн мөхснөөс хойш (XVI зууны дунд үе хүртэлхи) монгол дахь бурханы шашны түүхийг монгол⁴, түвэд⁵, хятад⁶ хэлний сурвалж болон

² Чан чун бумбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл. УБ.,1971, т.7

³ Ш.Бира. Монголын түүх түүх, соёл, бичлэгийн судалгаа III.УБ., 2000, т.291, Сүмбэ хамба Ишбалжир. Бурханы шашны түүх. ӨМАХХ.,1993, т.560

⁴ Хаадын үндсэн хураангуй алтан товч. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. монгол бичгээс хөрвүүлж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2002; Лувсанданзан. Алтан товч. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал.V // Монгол бичгээс хөрвүүлж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2006; Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршвой. монгол бичгээс харгуулан хөрвүүлж, тайлбар, хавсралт хийсэн Ц.Шагдарсүрэн, Э.Мөнх-Учрал. // Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал VII. УБ., 2006; Саган сэцэн. Эрдэнийн товч. Харьцуулан хөрвүүлж, оршил бичиж, тайлбар зүүлт хийсэн М.Баярсайхан // Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал VIII, УБ., 2006; Жамба. Асрагч нэргийн түүх. хөрвүүлж, тайлбар зүүлт, нэрийн хэлхээ хийсэн Д. Заяабаатар // Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. УБ.,2006; Гомбожав.Чингис эзний Алтан ургийн түүх Гангын урсгал нэрт бичиг оршив. монгол бичгээс. хөрвүүлж, тайлбар хавсралт хийсэн Б.Баттуяа, Ц.Батдорж, Б.Пүрэвдэлгэр // Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал X. УБ., 2006; Дөрвөн төрийн арван буянт номын Цагаан түүх. УТНС. (гар бичмэл), Ш.Бира. Хутагтай сэцэн хунтайжийн зохиосон нэгэн хуулийн тухай. ШУА-ийн мэдээ III, УБ.,1970,

⁵ Сүмбэ хамба Ишбалжир. Хутагтын эх орон Хятад, Түвэд, Монголын орон дор дээд ном ямар мэт дэлгэрсэн ёсны Галбарвасун модон хэмээгдэх оршивой. ӨМАХХ., 2003; Сүмбэ хамба Ишбалжир. Хөх нуурын домог. (түвэд хэлнээс орчуулж хайлбар хийсэн Д.Дашбадрах) УБ.,1996; Цэмбэл гүүш. Монголын бурхан шашны түүх. (Монголын түүх оршибай). (Л.Тэрбиш, Р.Бямбаа нар түвэд хэлнээс орчуулж тайлбарлав)УБ., 1997; Дарматала. Их Монгол оронд дээдсийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч Цагаан лянхуан эрхис хэмээгдэх оршивой. (түвэд хэлнээс орчуулсан Гомбожав).УБ.,1884

⁶ Сяо Да Хэ.Монголчуудын зан суртахууны тэмдэглэл. ӨМСХХ., 2004;

тусгайлсан судалгаа харьцангуй бага⁷, XV-XVI зууны эхэн үеийн төр шашны харилцааны асуудал ихээхэн бүрхэг тул зарим асуудлыг эргэн харах, нөхвөрлөх, тодруулах шаардлага зайлшгүй чухал байна. Юань улсын ноёрхол халагдан төрийн төв эх нутагтаа ирсэн үеэс дотоодын зөрчил тэмцэл хурцдан, хааны засгийн эрх мэдэл хазгаарлагдахын хирээр, шашин-төрийн үзэл уламжлагдан шашны тугийн дор нийт Монголыг нэгтгэн захирах гэсэн бодлого тухайн үеийн хаадын төрийн бодлогын төвд байсаар ирсэн ч түүхийн сурвалж хэрэглэгдхүүн хомс байдагтай холбоотой нэн тодорхой нягтлах боломж ховор юм. Тухайн үеийн хаад ноёдын шүтлэг Бурханы шашны Улааны урсгал, бөө мөргөлийн уламжлалт ёс, зан үйлтэй нэгдэн сүлэлдэж, уусан шингэж, шинэ дүр төрхтэй болсонтой холбоотой, нөгөө талаар хожмын улс орон даяар өрсөлдөн тэмцэлдсэн улаан, шарын урсгалуудын зөрчлийн улмаас үеэ өнгөрөөж голлох шүтлэг биш болсон учраас түүх баримт, мартагдан улиран оджээ.

Энэ үеийн монгол дахь бурханы шашны тухай XVII зууны үеийн монгол түүхийн сурвалж зохиолуудад Монголын Юань улсын сүүлийн хаан Тогоонтөмөр Бээжингээс ухран монгол газраа суух болсон тухай “Тогоонтөмөр хааны гэмшил” шүлэгт:

“Шашин төрийг дэлгэрүүлэн явтал”⁸

“Элдэв зүйлээр бүтсэн найман талт цаган сувраг шүтээн минь

Эн олон дөчин түмэн их Монгол гол улс минь

Хутагтан бурхадын байгуулсан наран мэт шашнаа

Хубилай сэцэн хааны тогтоосон хоёр сайхан ёсоо ...

... Хамгаар эрхлэн тогтоосон төр шашнаа

... Шуньди сэцэн би (Тогоонтөмөр)

Тэнгэрийн заяагаар алдвай төр шашныг...

... Гэгээн ухаантны дэлгэрүүлсэн наран мэт шашин ном (ыг)...

Гэндэж алдвай, Тогоонтөмөр хаан би Хятад улсад

Гийгүүлэн иртүгэй эзний алтан ураг Монгол улсад”⁹

хэмээн харуусан дуулсан тухай дурьдсан байна. “Түүнээс хойно... **шашин ном цөлийдсөн** (завсардсан) бүлэгээ”¹⁰ хэмээн тэмдэглэсэн байдаг. Энэ талаар монгол, хятад хэлний сурвалжид төдийлөн тэмдэглэгдэн уламжлагдаагүй тул бид, “шашин ном цөлийдсөн үе”, “хаадын төр-шашны бодлого үгүй болж”, “бөө мөргөл сэргэсэн”¹¹ хэмгээд “1570-аад оны дунд үеэс бурханы шашин шарын хэлбэрээр зонхилон дэлгэрэх болсон” зэргийг Түмэдийн Алтан ханы үйл ажиллагаатай холбон тайлбарлаж ирсэн.

⁷ Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ.,1978. т.135 Д.Гонгор. Халх товчоон. I,II, УБ.,1970,1978; Ч.Жүгдэр. XV-XVIII зууны Монголын нийгэм, улс төрийн гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. УБ., 1984; С.Пүрэвжав. Монголын шарын шашны хураангуй түүх. УБ.,1978; Н.Ишжамц. Түмэн засагт хааны төр-шашны бодлого. Mongolica.УБ., 1995

⁸ Лу Алтан товч. Монгол бичгээс хөрвүүлж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. Монголын түүхэн сурвалж бичгийн цувралV, УБ.,2006, т.232,

⁹ Дарма гүүш. Алтан хүрдэн мянган хигээст. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хавсралт хийсэн Т.Жамъянсүрэн, Л.Халиун.Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал XV, УБ.,2006, т.68-69

¹⁰ Лу Алтан товч. Монгол бичгээс хөрвүүлж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. Монголын түүхэн сурвалж бичгийн цувралV, УБ.,2006, т.234-235

¹¹ А.Н.Кочетков. Буддизм. М.,1983, с. 125

Тэгвэл монгол түүхэн сурвалж бичиг, Түвэдийн түүх, Түвэдийн бурхан шашны түүх, Мин улсын түүх зэрэгт цөөн боловч сонирхол татахуйц баримт үлджээ. Тухайн үеийн монголын хаад улс орны нэгдмэл байдлыг хадгалах, ард түмнийг захирч байх зорилгоор эртний уламжлалт бурхны шашны ёс журмыг баримталсаар байсан нь А.Тойнбийн өгүүлснээр “Иргэншлийн соёлын хөгжлийн дотоод хүчээ алдмагц холбоо бүхий харийн нийгмийн бүтцийн элементүүдийг аажмаар өөртөө шингээж эхэлдэг”¹²-ийн монгол дахь хамгийн тодорхой илрэл нь Бурханы шашин болж байсан.

XIV зууны сүүл үеэс хойшхи төр, шашны харилцааны түүхийг тухайн үеийн болон хожуу үеийн цөөн тооны монгол, түвэд хэлний тухайлбал, Түвэдийн түүх, бурхан шашны түүхийн он дараалалын тэмдэглэл бүхий ном зохиолуудыг үндэслэн зарим талаар тодруулах боломжтой юм. XIV зууны II хагасаас монгол оронд нэг талаар хаант төр - хүч чадал, улс орны нэгдмэл байдлаа, хууль цааз, шашин ёс суртахуунаар дамжуулан урт удаан хадгалах, нөгөө талд тус тусын ноёрхлоо бэхжүүлэхийн тулд улс төрийн зорилгоор шашин суртахууныг ашиглах, дэлгэрүүлэх хоёрдмол талтай байв. Юуны өмнө, монголын түүхэн сурвалждад Их хаадын намтар үйл ажиллагааг бичихдээ тэдгээр хаадын лам нь “хэн” байсныг тодорхой тэмдэглэсэн байдаг. Лувсанданзангийн “Алтан товч”-д Тогоонтөмөр ухаант хааны лам нь Буяны луу (Сажагийн Гунгаалодой жалцанбалсамбуу) нэрт бүлгээ ...түвэд нэр нь Ананда Мади”¹³ хэмээн дурьсан болон бусад цөөн тооны мэдээ баримт үлдсэн нь цөөн хэдий ч хаадын гэр өргөөгөөр дамжин шашин ном тасралтгүй уламжилж байсныг харуулж буй гэлтэй.

Юань улсаас хойшхи үеийн монголчуудын бурхны шашинтай холбоотой анхны мэдээ нь “Тойн Ирэнчинсамбууд (1390-ээд он) Мин улсаас уламжилсан захидал зарлиг” болно. Дундад үеийн монгол хэлний дурсгал дотроос агуулга ач холбогдол, хэмжээний хувьд ч хамгийн далайцтай нь нагиад үсгийн дурсгал болдог. Монгол хэлний нангиад үсгийн дурсгал болох толь бичгүүд олон байдгийн хэмжээ агуулга ач холбогдолоороо ч Монголын нууц товчооны дараа орох чухал дурсгал бол “Хуа-и-и-юй” (Нангиад харь хэлний орчуулга) юм. “Хуа-и-и-юй”-ын дэд дэвтэрт 12 захидал харилцааны бичгийг эмхтгэн оруулсны эхний 5 нь Мин улсын хаанаас монголчуудад буулгасан зарилаг, 7 нь монгол ноёдоос Мин улсад өргөсөн бичиг захидал байдгийн нэг нь энэхүү **“Тойн Ирэнчинсамбууд (1390-ээд он) уламжилсан зарилаг”** юм.Үүнд:

¹² А.Тойнби. Түүх судлал. УБ., 2007, т.267

¹³ Нангиад монгол “Хуа-и-и-юй толь”. УБ., 2005; Ө.Мандах. “Монгол И-юй бичиг”. Хөх хот.,199; Лувсанданзан. Алтан товч. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал V, монгол бичгээс хөрвүүлж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ.,2006, т.230, *Жамба*. Асрагч нэртийн түүх, хөрвүүлж, тайлбар зүүлт, нэрийн хэлхээ хийсэн Д.Заяабаатар Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. УБ., 2006, т.42,109, Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршив. Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хавсралт хийсэн Ц.Шагдарсүрэн, Э.Мөнх –Ундрал, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал VII, УБ., 2006, тал. 60,160, Гомбоваанжил. Монгол орноо шашин төр тогтсон ёсыг сайтар өгүүлсэн тунгалаг ухаант залуусын хоолрйн чимэг тунамал гэрэлт Алтан эрих, монгол бичгээс.хөрвүүлж, оршил бичиж,тайлбар хавсралт хийсэн Д.Бүрнээ, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал XVII. УБ., 2006, т. 57,153

“...Ойр Да Юань монголын заяан эцэс болж, хаан түшмэл харцас иргэн ангижран дүрвэлдэж умар газраа явахуйд, хүн тутам төмөд (төмөр) хуягуудыг өмсч, бат нум барьж, хурц сумнуудын шүүрч, өдөр шөнө үл осолдон, сая биеэ сахиад гэрээ төгсгөн (төрөө бэхэлж) чадаж он сар нөгчюү. Хэрэв зэвгүй гар хоосон шийдэм (дан) хувцсаар явж амгалангаар үүр (д) асугай (байсугай) хэмээн эрвээс үл болон ажуу”¹⁴ гээд бурхан номын үйл хүмүүний сэтгэлийг амгалан болгодог тул хатуу засгаас номын засгаар засах нь нэн эрхэм болохыг “Бурханы сургаал дөрвөн зүгийн иргэнд хүртэл дэлгэрч бүгд хүндлэн тахьжээ ... энэ ертөнцийн хүн амьтны сэтгэл нь маш олны тул яргай (хатуу ширүүн) засгаар засваас ... айлган үл чадна. Таван зүйл төрөөр удирдваас ... үл бишрэн ... бөгөөтөл бурхан номын нэр сонсоод цэцэн бээр мунхаг баясан сүжиглэгчин хэдэн тоон бүхийг үл мэдэгдэн ... сэтгэл дотроо өөрийгөө засагчин тоо томшгүй. Эгнэгт амьтныг үл алан эдгүүлэх чин зоригийн бэлгэ нь энэ мэт тэмдэг болон ажуу. Эдүгээд тойн Ирэнжинсамбуу... Шагмуний ёс дагаж, амьтныг үл алан, энэрх чин зоригийг барилталж ... Шагмуний номын төрийг үл устган, энэрэхүй ёсыг... номлож, хүн амьтны сэтгэлийг хөдөлгөн чадаж хорь илүү он болтол бэрх хэрвэл (хүнд бэрх, хатуу хөтүү) цагуудыг өнгөр(өн) билэгт тойн бус уу? Эдүгээ түүнийг Тайнин газрын Вань –шоу сүмийн жуци (дэмч) болгож Шагмунийн номын сургуулийг дэлгэрүүлж, номхон сайды (сайн) ба сөргүү хэцүүсийг номхотгон сурган атугай (хэн ч боловч) хүндлэн атугай ... аливаа алба гувчуур үл аван”¹⁵ хэмээн уламжлалт шүтлэгээр нь номхотгон барьж байх зорилгоор Урианхайн гурван харуулын монголчуудад залж байсан байна. Чухам тэр Тойн Ирэнчинсамбуу гэгч хэн болох ямар үйл ажиллагаа явуулж байсан нь тодорхойгүй ч дээрхи мэдээ монголчууд ба шашны талаар чухал баримт болон үлджээ. Зүүн түмний эзэн Мухулай ван 1219 онд Буддын шашны Лин-чи суртлын лам Хай-Юн (1202-1257) болон сажын ёсны лам хуврага¹⁶ -ыг залж, Бурхан суртал эрт үеэс энэ нутагт тархаж байсан нь Эзэнт гүрэн мөхсөний дараа ч уламжлал тасраагүй байжээ.

Түүнээс хойш шашин суртахууны тухай сурвалжийн мэдээ ховор бөгөөд “Юань улсын үед их хаан ширээнд суухын урьд улсын багш өргөмжилдөг ёсны дагуу Ойрадын Эсэн тайш монголын хаан ширээг булаан, 1453 онд өөрийгөө хаан өргөмжлөхдөө “Сэндаширийг улсын багш өргөмжлөв”¹⁷, “XV зууны үед Ойрадын Махамугийн дэргэд, Урианхайд бурханы шашны лам байсан аж”¹⁸, “III Далай ламыг угтагсадын дотор Түмэдийн (Ма чин) Махачин багш тэргүүлэн”¹⁹ хэмээн дурсан нь цөөн хэдий ч хаадын гэр өргөөгөөр дамжин шашин ном тасралтгүй

¹⁴ Нангиад монгол “Хуа-и и-юй толь”. УБ., 2005, тал.68-69, Ө.Мандах. “Монгол И-юй бичиг”. Хөх хот.,1995

¹⁵ Нангиад монгол “Хуа-и и-юй толь”. УБ., 2005, тал. 68-69, Ө.Мандах. “Монгол И-юй бичиг” Хөх хот.,1995

¹⁶ Ш.Бира. Монголын түүх түүх, соёл, бичлэгийн судалгаа III.УБ., 2000, т.291, Сүмбэ хамба Ишбалжир. Бурханы шашны түүх. ӨМАХХ.,1993, т.560

¹⁷ Монгол үндэстний нэвтэрхий түүх. Дунд дэвтэр. Бээжин.,1995

¹⁸ М.Санждорж. Монгол төрийн түүхээс. (XIII-XIX зуун) УБ.,1998, т. 144

¹⁹ Гомбоваанжил. Монгол орноо шашин төр тогтсон ёсыг сайтар өгүүлсэн тунгалаг ухаант залуусын хоолойн чимэг тунамал гэрэлт Алтан эрх. (монгол бичгээс.хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хавсралт хийсэн Д.Бүрнээ) Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал XVII. УБ., 2006, т. 52

уламжилж байсныг харуулж буй гэлтэй.

XIV зууны II хагасаас XV зууны эцэс хүртэл зуу орчим жилд хаадын улс төрийн бодлого, ялангуяа шашин төрийн үйл ажиллагаа тодорхой өгүүлэхэд бэрхшээлтэй. Юань гүрний нутаг хязгаарт Мин улсын нөлөө тогтон баруун өмнө хязгаар нутаг Амдо, Цайдам, Хөхнуур, Ордосын Бор тохой, Чигэн дэх монгол угсааны ноёдтой харилцах харилцаа холбоо суларч, Түвэд–Монголын бурханы шашин, соёлын харилцаа саарчээ.

Харин монгол, хятад түвэд сурвалжийн мэдээг нягталвал 1465 онд Мандуул хаан, Муулихай ун, Болох жонон нар өмнө тийш Хатан голын өмнө тохойд хүрч, Ордост зэрэг газарт нөлөөгөө бэхжүүлэхийн хамт, Амдо, Хөх нуурт ойртсон нь нутаг билчээрээ өргөтгөх, худалдаа арилжааны зам харгуйд дөхөх эдийн засгийн зорилго агуулахын зэрэгцээ цэрэг-улс төрийн байр сууриа бэхжүүлэх, Түвэдтэй уламжлалт шашин–төрийн харилцаагаа үргэлжлүүлэх бодлоготой уялдаатай байсан. “Мандуул, Болох жонон нар Түвэдэд элч илгээн, Гармын ёсны Хар малгайт болон Улаан малгайтныг залсан”²⁰ тухай Түвэдийн бурхан шашны түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. 1465 онд Мин улсын Чинхуа (成化) (1465 -1487) хаан Түвэдэд захидал бичиг илгээн, Гармын ёсны Хар малгайтны салбарын VII дүрийн Чойжижалсан хувилгааныг залахад “Монголын хаан, Ун (Ван гэж Болох жонон) ы урилга бичиг бас ирж”²¹ байжээ. Гэвч, тэр лам монгол газраа заларч ирсэн эсэх нь бас тодорхойгүй”. “Хөх дэвтэр”, “Дэвтэр нянбуу” зэрэг түвэдийн түүхэнд өгүүлснээр “Гармын ёсны Улаан малгайн салбарын VII дүрийн Чойжи Ишбалсан лам” 1465 онд Амдо орон(Силин хот)-д түр сууж, Монгол хааны урилгыг эрхэмлэн зүүн хойш голын тохойд ирээд Монгол хаан, жононтой уулзжээ. “Хаан жонон түүнийг хүндэтгэн угтаж, номын абшгийг баярлан хүртсэнд ... монголчуудад архины хор нүгэл, архи цээрлэхийг мэдүүлж, лам хуврагыг хүндэтгэх” номын ёсыг сурталджээ.²² Үүнээс хойш тэдний харилцаа, үйл ажиллагаа хэрхсэн нь тодорхойгүй монгол, хятад, түвэд сурвалжийн аль алинд дурьдсангүй.

Батмөнх Даян хаан өөрийн багш (лам)болон бөө хоёрыг илгээсэн тухай монгол сурвалжид товч дурьсан байна. Тухайлбал Лу “Алтан товч”-д: Хөвгүүнийг нь хороосон тул Даян хаан Баруун түмэнд цэрэглэн мордон, Далан тэргүүнд золголдох үед “...Алагчуудын Цагаан зайран, Үзэмчний Алдунгэ багш хоёул ёр төлөг үзэж хаанд айлтгав. Ибарайгийн амь нь гал буй. Галд ус хийвээс сайн буюу гэв. Гал түлж мөнгөн аягат усыг галд хийвэй. Оннигуудын Түлэгэдэй шинж шинжээч хэлэв. Боржигэн төрөлтэй дөрвөн улаан хүн гарч, хүнээс харил болсон хар хүн барс жолоотой дөрвөлжин хүн ирүүлд гарваас дарах гэв”²³,

²⁰ Намсрай. Гармагийн ёсон хийгээд Монгол хаадын харилцаа жич монгол орон дахь хөдөлгөөн. Умард үндэстний түүхийн судлал. (ӨМАХХ).1997, т.103

²¹ Ван Шан. Түвэдийн бурхан шашны хөгжлийн товч түүх. .1987 –д дурьдсаныг Намсрай өөрийн өгүүлэлдээ оруулжээ. (дээр дурьдсан зохиол тал. 103)

²² Хөх түүх (Дэвтэрнямбоо). Бээжин., т.358, Намсрай. Гармагийн ёсон хийгээд Монгол хаадын харилцаа жич монгол орон дахь хөдөлгөөн. (Умард үндэстний түүхийн судлал). ӨМАХХ.,1997, т. 103-104

²³ Лу Алтан товч. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал.V // Монгол бичгээс хөрвүүлж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. Монголын түүхэн сурвалж бичгийн цувралV, УБ.,2006, т.266-267,

Жамбын “Асрагч нэртийн түүх”-нд: “Алагчигудын Цагаан зайран, Үзэмчний Нэлдүнгэ багш хоёр ёр төлөг үзэж”²⁴ хэмээн цухас тэмдэглэгдсэн нь сонирхолтой бөгөөд өөр тоймтой мэдээ тэмдэглэгдэн үлдсэнгүй гэх боловч цаашид энэ асуудлыг нарийвчлан судлах монгол, түвэд, хятад, хэлний түүхэн сурвалж, баримт хэрэглэгдхүүнд тулгуурлан шинэлэг гаргалгаа, дүгнэлт хийх явдал зайлшгүй чухал юм.

Хожим монгол газраа Гэлүбагын шашин өргөн дэлгэрэх үед “III Далай ламыг угтагсадын дотор Түмэдийн (Ма чин) Махачин багш тэргүүлэн”²⁵ байсан тухай мэдээ бий.

“Түвэдийн бурхан шашны хөгжлийн товч түүх”-ээс үзвэл Гармын ёсны хар малгайтны салбарын IX дүрийн хувилгаан Ванчигдорж (1556-1603) Монголын нэг хаантай нягт харилцаатай²⁶ байсныг дурьдсан нь Монгол – Түвэдийн төр шашны харилцаа үргэлжилж, Монгол хаад улс орныг нэгтгэх үйлсэд бурхны шашны дэмжлэгийг олохыг чармайж байсан нь дамжиггүй. Дээр дурьдсан ламын амьдарч байсан цаг үе Монголд Түмэн засагт хааны төр барьсан үе бөгөөд монгол түвэд сурвалж бичгүүдэд “1576 онд улааны суртлыг баримтлагч Гарма ламыг ордондоо залж”²⁷, “Гарма лам (лугаа) учирч шашинд орж”²⁸, “Гарма ламыг учирч, бурхан шашныг их л бадруулав”²⁹ гэж тэмдэглэдэг. Түвэдийн шашны түүх сурвалжид, тэр лам нь Улаан малгайт V дүрийн хувилгаан Гончиг илдэний томилсон Енройсамбуу байв гэжээ. Түмэн засагт хаан суумагц улсын багш өргөмжлөх уламжлалын дагуу Улаан малгайтын Енройсамбуу цоржийг төрийн шашны тэргүүнээр залж, тахилын орон болгон шүтээд шашин төрийг энхжүүлэн мандуулахыг оролдсон тухай “тэрээр 38 –ны бин хулгана жил илдэн зангидагч Гарма лам лугаа учралдан шашны хаалганд” орсон тухай монгол сурвалжид тэмдэглэсэн байдаг нь тэрээр дээдсийн ёсыг мөрдөн эртний уламжлалт шүтлэг, монгол төр - шашныг бататгахын зэрэгцээ хаад ноёдын хүрээнээс гарган, нийтэд дэлгэрүүлэх шашин төрийн бодлогоор улс орноо нэгтгэн захирахыг чармайж “төр-шашны шинэчлэлт хийсэн”³⁰ юм.

Ёнройсамбуу (Ёонлон дахь Гарма лам) Түмэн заагт хааны тахилын оронд шүтэгдэж, төрийн шашныг төлөөлөн зургаан түмэн монголын улс төрийн төв Цахараар төвлөн ном тарни уламжлан, зүүн баруун түмэнд сургаал номлол дэлгэрүүлэх үйлсээ идэвхитэй явуулж байв. Таван отог Халх (Жаруд, Баарин, Хонгирад, Баяуд, Үжээд)-аар тойроод, Долоон отог ар Халхад өөдлөн, Ордос

²⁴ Жамба. Асрагч нэртийн түүх. (хөрвүүлж, тайлбар зүүлт, нэрийн хэлхээ хийсэн Д.Заяабаатар) Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. УБ., 2006, т. 55

²⁵ Гомбоваанжил. Монгол орноо шашин төр тогтсон ёсыг сайтар өгүүлсэн тунгалаг ухаант залуусын хоолойн чимэг тунамал гэрэлт Алтан эрх. (монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хавсралт хийсэн Д.Бүрнээ) Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал XVII. УБ., 2006, т. 52

²⁶ Намсрай, Гармагийн ёсон хийгээд Монгол хаадын харилцаа жич монгол орон дахь хөдөлгөөн, “Умард үндэстний түүхийн судлал”. ӨМАХХ., 1997, т.104

²⁷ Саган Сэцэн. Эрдэнийн товч. Хөх хот., 1999, т.383-385

²⁸ Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршив, монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хавсралт хийсэн Ц.Шагдарсүрэн, Э.Мөнх-Учрал, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал VII боть. УБ., 2006, т.70

²⁹ Ломи. Монгол Боржигид овгийн түүх, монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хавсралт хийсэн М.Баярсайхан, Р.Төрдалай, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал XI боть. УБ., 2006, т.1

³⁰ Энэ тухай өөр өгүүлэлд урьд нь дурьдсан тул энд дэлгэрэнгүй өгүүлсэнгүй.

түмэнд залагдан, Түмэд дэх чуулган зөвлөлгөөний үйл явдлуудад “оройн чимэг” болон залагдаж, олны хүндэтгэлийг хүлээж байжээ. Зарим талаар тухайн үеийн улс орны, ихэс дээдсийн хэрэгцээ шаардлагыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй үеэ өнгөрөөж буй шашин суртахууныг халж, шинэчлэх гэсэн хаант төрд үйлчлэн, шинэ шүтлэг бий болгоход ихээхэн үүрэгтэй хүн байжээ. Тэрээр Түмэдийн Алтан ханд хүндлэгдэн залагдаж, Түмэн засагт хааны зарилагаар III дүрийн Далай лам Содномжамцтай золгох уулзалтыг зохион байгуулж байсныг Алтан эрхид “Лам, шавь Хөх нуурт золгохыг тахилын лам Зундуйсамбууг илгээн айлтгуулав”³¹ гэж дурьдсан нь сонирхолтой бөгөөд “Содномжамц ламыг угтахын тулд Алтан хааны урилга хүлээж, Цавчаалын сүмд (Хөх нуурын) хүрэлцэн ирж I, II, III угтлага хүндэтгэлийн дараа хамгийн чухал угтагчид нь Енройсамбуу цорж болон... хоёр ламаар тэргүүлүүлсэн хүмүүсийг зохион байгуулжээ. Тэд 500 морьтныг дайчлан Алтан ханы дотоод сангаас мордон Содномжамц ламыг угтсан”³² байна. Түмэн засагт хаан Содномжамцыг Монгол газраа өөдлөн заларч ирэхэд Түмэдийн Сүн дүүрэн, лам Енройсамбуу цорж нарыг онцгойлон Ордос зүг илгээжээ. Тэрээр Ордосын ноёдыг удирдан “Хатан голын Шивэр” нэрт газар Содномжамцыг угтан авчээ.³³ Монголчууд Содномжамцыг III Далай лам хэмээн өргөмжлөн, шашны шинэчлэлт хийсэн нь цоо шинэ зүйл биш бөгөөд урьдын шашны уламжлалт, Монгол хаадын үйл ажиллагаатай хлбоотой байсан. Буддизм “Будда, Далай лам зэрэг шууд хүнээр танигдана”³⁴. Буддизмын хөгжил дэх ламын шашны хэлбэр нь халисан хүнийг хүндэлдэг түрүү үеийн буддизмыг бодвол жинхэнэ амьд хүнийг дээдэлдгээрээ³⁵ олны итгэл бишрэлийг улам ихээр хүлээх болсон. Цахар, Түмэд, Ордос, Халхын ноёд төр –шашны алив үйлд хааны зарлигаар төрийн багш –тахилын лам Енройсамбууг хүндэтгэн залж, түүний санаачлага дэмжлэгийг хүртэж байсан.

Ер нь улаан, шарын урсгалыг илт сөргөлдүүлэн ойлгож ирсэн нь хожмын улс төрийн үйл явцаас үүдэлтэй бололтой. “Шашин...эвдэрч буснисан иргэншлийн уналтыг зогсоох, сүйрлийг нь зайлуулах гэсэн оролдлогын илрэл болсон нэгдмэл төрийн улс төрийн үйл ажиллагаа” тул Монголын хаад, ноёд энэ үед шашин суртахууныг төрийн үндэс болгож, улс орныг нэгдмэл байлгах, зөрчил тэмцлийг халах зорилгоор “улаан шар гэж үл ялган” хүндэтгэлтэйгээр хандан уламжлалт ёс журмын дагуу шашны дээд үйлийг “төрийн багш” шашны лам хуврага тэргүүтнээр эрхлүүлэн, элч болгон ном ёс уламжилж, шинэчлэлт зүйлийг хийжээ.

Ийнхүү Юань улсаас хойш ч Бурханы шашны олон урсгалууд, бөө мөргөлийн уламжлалт ёс, зан үйлтэй нэгдэн сүлэлдэж, уусан шингэж, шинэ дүр төрхтэй болон өнө удаан оршин тогтносон түүхэн уламжлалтай билээ.

³¹ Гомбоваанжил. Монгол орноо шашин төр тогтсон ёсыг сайтар өгүүлсэн тунгалаг ухаант залуусын хоолрын чимэг тунамал гэрэлт Алтан эрих, монгол бичгээс.хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хавсралт хийсэн Д.Бүрнээ, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал XVII боть. УБ., 2006, т. 51

³² Чагаварди Алтан ханы тууж. УБ., 2006, т.132-166

³³ Намсрай, Гармагийн ёсон хийгээд Монгол хаадын харилцаа жич монгол орон дахь хөдөлгөөн. “Умард үндэстний түүхийн судлал”. ӨМАХХ.,1997, т.108-109

³⁴ Гегель. Философия религий в 2-х томах. М.,1976, Т-I, с.518-519

³⁵ Гегель. Соч.Т-8, М.,1935, с.160

Abstract: *Some researchers have pointed out that shamanism was restored because of the disappearance of the “secular-religious” policy during the time of post-Yuan rulers. However, in written sources we can find some, although few, information concerning the history of Buddhism of the early 15-16th centuries. Particularly, they are related to Usgal, Enkhzorigtu, Esen Taishi, Manduul Khan, Bolkhu Jinon, Batmūngke Dayan Khan and Tūmen Zasagtu Khan. The information indicate that various Buddhist sects were eventually merged with ancient shamanistic practices and rituals in the post-Yuan period to form a new character.*